

Монголын Эрчим хүч, геологи, уул уурхайн ҮЭ-ийн холбооны Тэргүүлэгчдийн хурлын 2016 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн 13 тоот тогтоолын 2 дугаар хавсралтаар батлав.

МОНГОЛЫН ЭРЧИМ ХҮЧ, ГЕОЛОГИ, УУЛ УУРХАЙН ҮЭ-ИЙН ХОЛБООНЫ ГИШҮҮН ҮЭ-ИЙН ХОРООД МӨНГӨН ХӨРӨНГӨ ЗАРЦУУЛАХ ЖУРАМ

Үндсэн нэгжийн ҮЭ-ийн хороод нь бүх гишүүдийн хурлаар баталсан тухайн оныхоо төсвийн дагуу тэргүүлэгчдийн тогтоолыг үндэслэн мөнгөн хөрөнгийг доорхи чиглэлд зарцуулна. Үүнд:

1.Сургалтын зардал

Энэ нь нийт зардлын 20 хүртэл хувийг эзлэх бөгөөд доорхи чиглэлд зарцуулна.

- 1.1 ҮЭ-ийн гишүүдийн ажлын байран дээрхи бичил сургалтууд
- 1.2 ҮЭ-ийн гишүүдийн эдийн засаг, хууль эрх зүйн мэдлэгийг дээшүүлэх
- 1.3 ҮЭ-ийн талаархи сургалт
- 1.4 Хамтын гэрээг сурталчлах
- 1.5 Идэвхтэн, сонгуультны үйл ажиллагаанд чиглэсэн сургалт
- 1.6 Сургалтын материалаг баазыг бэхжүүлэх
- 1.7 Салбарыг ҮЭ-ийн холбооноос зохион байгуулж буй сургалтын нэгдсэн арга хэмжээ
- 1.8 ҮЭ-ийн гишүүдийн амьжиргааг дээшлүүлэх чиглэлийн сургалт

2.Халамжийн сангийн зардал

Энэ нь нийт зардлын 20 хүртэл хувийг эзэлнэ. Сангийн журмыг ҮЭ-ийн холбооны тэргүүлэгчдийн хурлаар баталж мөрдөнө. Сангийн хөрөнгийг доорхи чиглэлд зарцуулна.

- 2.1 ҮЭ-ийн гишүүний давуу эрхийг эдлүүлэх зорилгоор амралт сувилалын хөнгөлөлт олгоно.
- 2.2 ҮЭ-ийн гишүүдэд амьдралын гачигдал зовлон, байгаль цаг уурын болон гэнэтийн хохирол, эрсдэл учирсан үед дэмжлэг тусламж үзүүлнэ.

3.Идэвхтний зардал

Энэ нь нийт зардлын 10 хувийг эзлэх бөгөөд тухайн ҮЭ-ийн хорооны идэвхтэн сонгуультан болон нийт гишүүдэд чиглэсэн томоохон арга хэмжээг санхүүжүүлнэ.

- 3.1 Идэвхтэн сонгуультны ажлыг дүгнэж, шагнаж урамшуулах
- 3.2 Хурал зөвөлгөөн, тайлангийн болон тайлан сонгуулийн хурал
- 3.3 Спорт, урлагын арга хэмжээ
4. ҮЭ-ийн гишүүдийн ажлын бүтээмж, идэвхийг өрнүүлэх зорилгоор захиргаатай хамтран зохиосон компани ажил, болзолт уралдааны тодорхой хувийг гаргах гэх мэт

4.Шагнал урамшуулал

Тухайн ҮЭ-ийн хорооны шагналын журмыг тэргүүлэгчдийн хурлаар баталж мөрдөнө. ҮЭ-ийн хороо болон аж ахуйн нэгжийн томоохон ойн арга хэмжээ онцлог үйл явдлын үед сайн ажилласан гишүүдийг шагнах, алдаршуулах, дээд байгууллагын шагналд тодорхойлж дагалдах мөнгийг гаргах гэх мэт зардал байх бөгөөд тухайн жилдээ 10 хүртэл хувийг зарцуулах

5.Соёл олон түмэн, биен тамирын арга хэмжээ

Энэ нь ҮЭ-ийн гишүүдийг хамруулсан томоохон спорт урлагын арга хэмжээ, байгууллагын аваргуудад хүндэтгэл үзүүлэх, тойрон аялал зохион байгуулах, шинэ жил болон тэмдэглэлт ойн арга хэмжээг зохион байгуулахад чиглэсэн дангаараа болон захиргаатай хамтарч хийх ажлын зардал байна. Тухайн жилийн нийт зардлын 10 хүртэл хувь байна.

6.Томилолт бичиг хэрэг, хэвлэл, сурталчилгаа

Энэ нь тухайн жилийн нийт зардлын 5 хүртэл хувь байна. Хөдөлмөр сонин, Төрийн мэдээлэл зэргийг захиалж болно. Эдгээрээс өөр хэвлэл ҮЭ-ийн хөрөнгөөр захиалахыг хориглоно.

6.1 ҮЭ-ийн байгууллага болон ҮЭ-ийн хорооны үйл ажиллагааг сурталчлах ажлыг зохион байгуулах

6.2 Банкны данс хөтөлсөн шимтгэл болон ҮЭ-ийн хорооны албан тоот, тогтоолын бланк, бусад холбогдох бичиг хэргийн зардал, томилолтын зардал

7.Үндсэн ажлаасаа чөлөөлөгдөөгүй ҮЭ-ийн хорооны дарга, ня-бо, нярав болон ҮЭ-ийн татвар хураасан цалингийн ня-бо нарт олгох урамшуулал

Энэ нь нийт зардлын 20 хүртэл хувийг эзэлнэ.

7.1 Үндсэн ажлаасаа чөлөөлөгдөөгүй ҮЭ-ийн хорооны дарга ня-бо нарын урамшууллыг ҮЭ-ийн хорооных нь санхүүгийн чадавхитай уялдуулан эрчим хүч, геологи, уул уурхайн ҮЭ-ийн холбооны Тэргүүлэгчдийн хурлаас тогтоож өгнө. Үүнд Салбарын ҮЭ-ийн холбооны Хяналтын хорооноос зөвлөх эрхтэй оролцоно.

7.2 ҮЭ-ийн хорооны нярав болон татвар хураасан цалингийн ня-бо нарт улиралд хураасан татварын 1-3 хүртэл хувийг хувааж олгож болно.

8. Зээлдэн туслах сан

8.1 ҮЭ-ийн хороод нь ҮЭ-ийн гишүүдэд зориулан энэхүү санг ажиллуулж болно.

8.2 Сангийн дүрмийг Салбарын ҮЭ-ийн холбооны Тэргүүлэгчдийн хурлаар оруулан батлуулж мөрдөнө. Дээрхи дүрмээр сангийн үйл ажиллагааны зохион байгуулалт, сангийн үйл ажиллагааны зардлын тодорхой дагаж мөрдөх бөгөөд сангийн үйл ажиллагааны талаар хагас, бүтэн жилд тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцэж байна.

8.3 Сангийн үйл ажиллагааны нягтлан бодох бүртгэлийг зөв хөтөлж санхүүгийн тайлант тусгана

9.Үндсэн хөрөнгө

ҮЭ-ийн хороод нь шаардлагатай хөрөнгийг худалдан авч болох бөгөөд энэ талаар ҮЭ-ийн холбооны даргын зөвлөлөөр баталсан журмыг мөрдөж ажиллана. Үндсэн нэгжийн ҮЭ-ийн хороод нь дээрхи чиглэлээр мөнгөн хөрөнгийг зарцуулна. Эдгээрээс өөр зүйлд мөнгөн хөрөнгийг зарцуулахыг хориглоно.

10.Мөнгөн хөрөнгийн тайлан

ҮЭ-ийн хороод салбарын ҮЭ-ийн холбооны баталсан маягтын дагуу жил бүр санхүүгийн тайлан гаргаж жил бүрийн 1 дүгээр сарын 20-ны дотор салбарын ҮЭ-ийн холбоонд ирүүлнэ.